



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ

2022...он 01 сар 12 өдөр

Дугаар: 06/2022

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ГАДААД
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭСТ

Үйл ажиллагааны тайланг хүргүүлэх тухай

БОАЖЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн I болон II шатны Үйл ажиллагааны тайланг 2021 оны жилийн эцсийн байдлаар тус тус гарган, хүргүүлж байна.

Хавсралт 43 хуудастай.

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ *Т. Гэрэнзбаясгалан* ГЭРДЭНЭБАЯСГАЛАН



Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
нийтлэг журмын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ
ТУСЛАМЖААР ХЭРЭГГИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

№	Төслийн агуулга	Гүйцэтгэл
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	<p>Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II/III төсөл Шийдвэр: БОЯБХУАӨДЗ II төсөл: Монгол-Германы Засгийн газар хооронд 2018 оны 6 сарын 22-нд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр БОЯБХУАӨДЗ III төсөл: Монгол-Германы Засгийн газар хооронд 2019 оны 6 сарын 26-нд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр Төслийн дугаар: BMZ 2016 67 054; BMZ 2018 68 272 Төслийн зорилго: Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн болон нийлмэл/холбоос нутгуудын (орчны бүс болон экологийн коридор, кластер) тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.</p>
2	Санхүүжилтийн эх үүсвэр	ХБНГУ-ын Засгийн газар - Буцалтгүй тусламж Монгол Улсын Засгийн газар
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ, Төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх баг.</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, ТХБНУГ-ын хамгаалалтын захиргаад</p> <p>Хэрэгжих хугацаа: 7 жил: 2020.03.02 - 2027 /II, III үе шат/</p>
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1: Улсын хэмжээний ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэглэлээр хангах.</p> <p>Зорилт 2: Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу Кластер нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх.</p> <p>Зорилт 3: Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон ТХГ-ыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх</p> <p>Зорилт 4: ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p>

5	Зардал	Төсөв (Нийт зардал)	Төслийн II үе шатны нийт төсөв 32.8 сая евро. ХБНГУ-ын Засгийн газар 27.5 сая евро, Монгол Улсын Засгийн Газар 14.8 тэрбум төгрөг			
		Үүнд:	Төсөв (2021 он)	Гүйцэтгэл		Хувь
		ХБНГУ-ын Засгийн газар	3,379,000,0 00.0 төгрөг	1,012,266.15 евро	3,353,027,407.88 төгрөг	99.2 %
		МУ-ын Засгийн газар	735,545,80 0.0 төгрөг	205,305.05 евро	697,066,566.54 төгрөг	94.8 %
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	2021 оны Үйл ажиллагааны /2021.05.24-ний өдөр / шинэчилсэн төлөвлөгөөний дагуу биелэлтийг гаргав.				
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах	<p>1. Биологийн олон янз байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээ (5 кластер) /ҮАТ 1.01./: Ажлын даалгавар, тендерийн баримт бичгийн төслийг боловсруулсан. Кластер нутгуудад тархсан түлхүүр зүйлүүд нь Кластер 1, 2: Цоохор ирвэс Snow leopard, Аргаль хонь, Кластер 3: Халиун буга, Бор гөрөөс, Кластер 4: Бөхөн, Хар сүүлт, Аргаль хонь, Кластер 5: Хулан адуу, Тахь адуу-, Хар сүүлт тодорхойлсон. ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээний жишиг баримт бичигт санхүүжүүлэгч талаас 2021 оны 12 сарын 21-ний өдөр зөвшөөрөл хүлээн авсан тул тендерийг 2022 онд зарлахаар шилжүүлсэн. Төслийн кластер бүс нутаг дахь УТХГ болон ОНТХГ-уудад биологийн олон янз байдлын түлхүүр зүйлүүдийн тархалт, нөөц, сүргийн бүтэц, нүүдэл шилжилт хөдөлгөөн (эко корридор) нутгуудыг тодорхойлох талаарх суурь мэдээллийг бүрдүүлэх зорилготой. Ажлын гүйцэтгэл 20%</p> <p>2. Нийгэм эдийн засгийн суурь судалгааны зөвлөх үйлчилгээ (кластерын 5 аймгийн 18 суманд) /ҮАТ 1.02./: Төсөлд хамрагдаж байгаа бүх Кластерын хэмжээнд Нийгэм, эдийн засгийн суурь судалгаа явуулахаар шийдвэрлэж ажлын удирдамж, аргачлалыг эцэслэн боловсруулж KfW-д хүргүүлсэн. Тайлант хугацаанд Нийгэм, эдийн засгийн суурь судалгааны ажлын удирдамж, аргачлалыг дахин хянаж сайжруулах, төслийн хүрээнд гарах үр дүнгийн индикаторуудыг тодорхой болгох зорилгоор Олон улсын зөвлөх хатагтай Элке Хэллстэрнийг ажиллуулж байна. ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээний жишиг баримт бичигт санхүүжүүлэгч талаас 2021 оны 12 сарын 21-ний өдөр зөвшөөрөл хүлээн авсан тул тендерийг 2022 онд зарлахаар шилжүүлсэн. Ажлын гүйцэтгэл 20%.</p> <p>3. Ойн тогтвортой менежментийн суурь судалгааны зөвлөх үйлчилгээ (3 аймгийн 10 суманд) /ҮАТ 1.03./: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/57 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/153 дугаартай тушаалаар 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр 45,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-2/1621, 21/194 дугаартай гэрээг "ШУТИС-ийн ой модны сургалт, судалгааны хүрээлэн"-тэй байгуулсан. Гэрээний дагуу зөвлөх үйлчилгээний тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн</p>				

<p>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах</p>	<p>хурлаар 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хэлэлцэж, үүрэг даалгаврын биелэлтээр тус ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. 2021 онд багтан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>4. Бэлчээрийн тогтвортой менежментийн суурь судалгааны зөвлөх үйлчилгээ (3 аймгийн 10 суманд) /ҮАТ 1.04./: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/58 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулсан. Энэхүү худалдан авах ажиллагааг KfW -гаас өгсөн зөвлөмжийн дагуу МЕТТ-ийн суурь судалгааны зөвлөх үйлчилгээний тендерийн бүх үе шатны процессыг дагуулан явуулж байна. Бэлчээрийн менежментийн суурь судалгааны тендерийн урьдчилсан шалгаруулалтыг 11 дүгээр сарын 16-ны өдөр хийж хураангуй жагсаалтад орсон байгууллагуудад урилга хүргүүлсэн. Техникийн саналын үнэлгээг 12 дугаар сарын 27-нд хийж, сонгогдсон байгууллагатай гэрээ байгуулахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 50%</p> <p>5. ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээ (22 УТХГ, 1 ОНТХГ) /ҮАТ 1.05./: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/57 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулсан. Тендерийн үнэлгээний эцсийн тайланд KfW-аас 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зөвшөөрөл хүлээн авсны дагуу 70,400,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг "Эко Ази" Байгаль орчны сургуультай байгуулах мэдэгдлийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлж, сонгогдсон байгууллагатай гэрээ байгуулахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 50%</p> <p>6. Кластерын менежментийн сангийн үзэл баримтлалын журмыг боловсруулж, батлуулах /ҮАТ 1.06./: Төслийн I шатны зээлийн эргэлтийн сангийн үр дүнд суурилан тус журмыг боловсруулах бөгөөд тус эргэлтийн сангийн зээлийн ажиллагаа 2021 оны 09 дүгээр сард эхэлсэн тул үр дүнг үнэлэх боломжгүй байна. Иймд тус ажлын хугацаа хойшилж, 2022 оны үйл ажиллагаа руу шилжсэн. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.</p> <p>7. Кластерын менежментийн төлөвлөгөөг боловсруулах /ҮАТ 1.07./: Кластерын менежментийн төлөвлөгөөг 2-р Кластерын хэмжээнд загвар байдлаар боловсруулах Зөвлөх багийг сонгон авч ажиллуулан, эхлэлийн семинарыг 2021 оны 11 сарын 02-нд Ховд хотод зохион байгуулсан. Зөвлөх баг 11 дүгээр сарын 3-13-ны өдрүүдэд 2-р кластерт хамрагдах Мөнххайрхан, Мянган Угалзатын БЦГ-ын ХЗ, Хар Нуур Ховд голын ХЗ Орчны бүсийн Ховд, Мөст, Цэцэг, Алтай, Мөнххайрхан, Алтай, Булган, Үенч, Дуут зэрэг 8 орчим суманд ажиллаж, сумын удирдлагууд, БОУБ, газрын даамал, ХАА мэргэжилтэн, багийн ЗД нар, УТХГН-ийн ХЗ-ны дарга мэргэжилтнүүд, сав газрын захиргааны мэргэжилтнүүд, нөхөрлөл, хоршоодын төлөөлөл, малчид, иргэдийн төлөөлөл нийт 90 гаруй хүнийг оролцуулсан уулзалт ярилцлага зохион байгуулсан. Тус баг судалгааны явцад цуглуулсан мэдээлэл,</p>
---	--

	<p>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах</p>	<p>материалыг боловсруулах, КМТ-ний эхний хувилбарыг бэлэн болгохоор ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 70%</p> <p>8. Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих багийг сонгон шалгаруулах /ҮАТ 1.08./:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/173 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хорооны хурлыг 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, зөвлөхийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийн төслийг хэлэлцсэн ба баримт бичгийг захиалагчаар батлуулж, тендерийг 2022 оны 01 дүгээр сард зарлахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 20%</p> <p>9. Төслийн хүрээнд шинээр баригдах хамгаалалтын захиргааны барилга, баруун бүсийн СМСТ-ийн барилгын ТЭЗҮ хийж, концепци боловсруулах /ҮАТ 1.09./:</p> <p>Төслийн зөвлөх баг Баруун бүсийн СМСТ-ийн хөгжлийн концепцийг боловсруулсан ба 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр цахим уулзалт зохион байгуулж, холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. Ховд аймгийн Засаг даргын 22021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/149 дугаартай захирамжаар Бүсийн төвийн барилгын зураг төслийн ажлын даалгавар боловсруулах, зураг төслийн ажилд хяналт тавих тус аймгийн төлөөлөл, ИНХ болон бусад оролцогч талуудаас бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, бүсийн төвийн барилгын ТЭЗҮ хийж, концепцийг эцэслэсэн. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>10. Төслийн хүрээнд шинээр баригдах барилгуудын хөрсний геологи, геодезийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ /ҮАТ 1.10./:</p> <p>"Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих багийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээ" /ҮАТ 1.08./ тендерээр шалгарсан баг нь тус тендерийн ажлын даалгавар, концепцийг гаргахаар төлөвлөсөн тул зөвлөх баг шалгарахыг хүлээж байна. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.</p> <p>11. Кластерт хамрагдсан байгаль орчны байгууллагууд, ТХГ-ын захиргаатад шаардлагатай судалгааны болон үндсэн багаж тоног төхөөрөмж нийлүүлэх /ҮАТ 1.11./:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/228 дугаар тушаалаар үнэлгээний хороог шинэчлэн байгуулсан. Ажлын даалгаврыг эцэслэн боловсруулж, БОАЖЯ-ны ТХБНУГ-т санал хүргүүлсэн, захиалагчаас тус тендерээр худалдан авах барааны тоо ширхэг болон хуваарилалтыг ирүүлэхийг хүлээж байна. Эцэслэсэн ажлын даалгавар болон тендерийн баримт бичгийг КfW-д хүргүүлэн, зөвшөөрлийг авч, тендерийг 2022 оны 01 дүгээр сард зарлахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 20%</p> <p>12. Байгаль хамгаалагчдыг өвөл, зуны дүрэмт хувцсаар хангах /ҮАТ 1.12./:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/458 дугаар тушаалаар сонгон шалгаруулах үнэлгээний хороог</p>
--	---	--

<p>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах</p>		<p>байгуулсан. БОАЖ-ын сайдын 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/176 дугаар тушаалаар ТХГН-ийн байгаль хамгаалагчдыг өвөл, зуны дүрэмт хувцасны стандартыг батлуулсан. Сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан хэдий ч шаардлага хангасан тендер ирээгүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болсон. Тендерийн үнэлгээний хорооны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар тендерийг 2022 оны 01 дүгээр сард дахин зарлахаар шийдвэрлэсэн. Ажлын гүйцэтгэл 20%</p> <p>13. Бурхан Халдун хайрхны орчны бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын загвар төсөл хэрэгжүүлэх /ҮАТ 1.13./: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/169 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороог байгуулсан. Бурхан Халдун тахилгат газар нутагт загвар төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан БОАЖЯ, Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төв, Төв аймгийн Мөнгөнморьт сумын ЗДТГ, Хан Хэнтийн УТХГ, Дэлхийн өв-Юнескогийн Монголын үндэсний комисс, Бурхан халдун Уул ТХГН-ийн ХЗ, ТХН, төслийн зөвлөх баг төлөөлөл оролцсон хамтарсан уулзалтыг 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Тус хурлаар Хан Хэнтийн УТХГ-ын ХЗ нь Юнескогийн Монголын үндэсний комиссоор дамжуулан "Дэлхийн өвийн төв"-д ТХГ-ын Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн ерөнхий үнэлгээ, ажлын зураг, концепцийг танилцуулах, зөвшөөрөл авах шаардлагатай болсон тул Хан Хэнтийн УТХГ-ын ХЗ-наас 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр тус ажлыг цуцлах хүсэлтээ ирүүлснийг 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн төслийн удирдах хорооны хурлаар хэлэлцээд тус ажлыг цуцалж, үнэлгээний хороог татан буулгахаар шийдвэрлэсэн. Ажлын гүйцэтгэл цуцлагдсан.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх</p>		<p>1. Кластерт хамрагдсан байгаль орчны байгууллагууд, ТХБНУГ-т бартаат замын автомашинаар хангах /ҮАТ 2.01/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/13 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хорооны 01 дүгээр хурлыг 2021 оны 03 дугаар сарын 03-нд зохион байгуулж, ажлын даалгавар, тендерийн баримт бичгийн төсийг эцэслэн боловсруулсан. Тендерийн зарыг төслийн веб сайт, БОАЖЯ-ны цахим сайт болон өдөр тутмын сонин хэвлэлд 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зарласан. Сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан хэдий ч шаардлага хангасан тендер ирээгүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болж, тендерийг дахин зарлахаар шийдвэрлэсэн. Кластерт хамрагддаг 5 аймгийн БОАЖГ, УТХГН-ийн 10 хамгаалалтын захиргаа, Усны сав газрын 2 захиргаанд тус бүр нэг нийт 17, БОАЖЯ-нд 1 нийт 18 автомашин нийлүүлэх олон улсын нээлттэй тендерийн (MON ICB 03/2020) 09 дүгээр сарын 13-ны өдөр дахин зарласан ба 10 дугаар сарын 28-нд тендерийн нээлт хийж, 11 дүгээр сарын 03-ны өдөр эцсийн шатны үнэлгээ хийж, KfW банканд 11 дүгээр сарын 30-нд үнэлгээний тайланг хүргүүлсэн бөгөөд зөвшөөрлийг санхүүжүүлэгч байгууллагаас хүлээж байна. Ажлын гүйцэтгэл 50%</p> <p>2. Зүүнгарын говийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангах /ҮАТ 2.02/:</p>

<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11-р сарын 24-ний өдөр А/376 дугаар тушаалаар Говийн Их ДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны нэрийг “Зүүнгарын говийн ДЦГ-ын хамгаалалтын захиргаа” болгон өөрчилж тус хамгаалалтын захиргааг Ховд аймгийн Алтай сумын төвд шилжүүлэн байршуулахаар шийдвэрлэсэн шийдвэрийг өөрчилж, ГИДЦГ-ын “Б” хэсгийг Говь-Алтай, Ховд аймгийн засаг захиргааны нэгжийн хилээр зааглан 2 тусдаа хамгаалалтын захиргаатай байх, Ховд аймгийн нутаг дэвгэрт хамаарах хэсгийг хариуцсан хамгаалалтын захиргааг шинээр байгуулахаар шийдвэрлэсэн. Ажлын хүрээнд ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны Мастер төлөвлөгөөг үндэслэн барилгын суурийн геологи, гидрологи, геодезийн дүгнэлт гаргах, барилгын ажлын зураг төсөл, төсвийг боловсруулах ажлыг Олон улсын Тахь группын хөрөнгөөр “Билдинг Техноложи” компани гүйцэтгэсэн. Зураг төсвийг KfW банкны холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулан, санал, зөвлөмжийг тусган сайжруулж, Монгол Улсын Барилгын Хөгжлийн Төвөөр батлуулахаар хүргүүлээд байна. Зураг төсөл, төсөв батлуулж, барилгын Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэснээр тендерийг зарлах бэлтгэл ажил хангагдана. Ажлын гүйцэтгэл 70%.</p> <p>3. Төслийн кластеруудын хэмжээнд нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих үйл ажиллагаануудын концепци болон бизнес төлөвлөгөөг боловсруулах /ҮАТ 2.03/:</p> <p>Төслийн кластеруудын хэмжээнд Тогтвортой амьжиргааны үзэл баримтлалыг төслийн зөвлөх баг богино хугацааны зөвлөх ажиллуулан боловсруулж байна. Ажлын гүйцэтгэлийг гэрээний дагуу 2022 оны 01 дүгээр сард хүлээн авна. Ажлын гүйцэтгэл 70%.</p> <p>4. Төслийн кластеруудын хэмжээнд нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх /ҮАТ 2.04/:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/94 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулан, сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/170 дугаартай тушаалаар 689,111,180.00 төгрөгийн үнийн дүн бүхий ҮТБ-№02/0621 дугаартай гэрээг “Мөнх ногоон тал” ХХК-тай 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу төслийн 5 кластерын хэмжээнд нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор гурван улирлын иж бүрэн хүлэмж 22, бага оврын услалтын иж бүрэн систем 23-ыг зорилтот хэсэгт 2022 оны 06 дугаар сард нийлүүлэхээр ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 50%.</p> <p>5. ТХГН дахь хог хаягдлын менежментийн зөвлөх үйлчилгээ /ҮАТ 2.05/:</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/57 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/151 дугаартай</p>
---	--

	<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>тушаалаар 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдөр 27,950,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-2/1721, 21/193 дугаартай гэрээг “Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн” ТББ-тай байгуулсан. Гэрээний дагуу загвар төслийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хэлэлцэж, тайланг сайжруулах үүрэг даалгавар өгсөн. Гүйцэтгэгч байгууллага хэлэлцүүлгийн үеэр өгсөн санал зөвлөмжийн дагуу тайланг 2022 оны 01 дүгээр сард эцэслэн ирүүлнэ. Гэрээний хугацаа 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр, 2022 эхний улиралд багтан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 50% байна.</p>
	<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан 7 ТХГ-ыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>1. Төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дэмжлэг үзүүлэх 7 хүртэлх Тусгай хамгаалалттай газрыг сонгож, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах /ҮАТ 3.01/: Төсөл хэрэгжүүлэгч нэгж, төслийн зөвлөх баг, БОАЖЯ-тай хамтран төслийн I II үе шатанд хамрагдаагүй 7 хүртэлх хамгаалалтын захиргаадыг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан эхний ээлжинд нийт 5 хамгаалалтын захиргаадыг сонгохоор хэлэлцсэн. ТХБНУГ, ТХН, Төслийн Зөвлөх Багийг төлөөлсөн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдон санал болгосон дээрх ТХГН-дын нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан ба шалгуурыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгч 60-аас дээш оноо авч шаардлага хангасан дараах 5 ТХГН-ийг сонгосон. Шалгуурын дагуу үнэлгээ хийхэд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дарьгангын БЦГ /99 оноо/, 2. Их Богдын БЦГ, /95 оноо/, 3. Монгол Элсний БЦГ /93 оноо/, 4. Их Газрын Чулуу БЦГ, /80 оноо/, 5. Говь Гурвансайханы БЦГ /84 оноо/ тус тус авсан. Ажлын гүйцэтгэл 70% <p>2. Сонгогдсон ТХНГ-уудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах /ҮАТ 3.02/: Тус ажил төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дэмжлэг үзүүлэх 7 хүртэлх хамгаалалтын захиргаадыг сонгох дээрх /ҮАТ 3.01/ ажилтай уялдан хийгдэнэ. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.</p>
		<p>1. СЯ, БОАЖЯ, ТХБНУГ болон бусад талуудтай хууль эрх зүй, бодлого зохицуулалтын уулзалт, кластерын зөвлөгөөн, хэлэлцүүлэг, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ зохион байгуулах /ҮАТ 4.01/: Тайлант хугацаанд Төсөл хэрэгжүүлэгч нэгж, Зөвлөх баг, БОАЖЯ болон бусад оролцогч талуудыг чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэхүү сургалт, уулзалт зөвлөгөөнийг цар тахлын үед мөрдөх журмыг баримтлан цахимаар зохион байгуулсан болно.</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бодлого /2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр/ • ТХГН-ийн сүлжээ, ТХГН-ийн менежментийн үр ашигт байдал /2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр/

	<p>4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> • Холбоос нутгийн үзэл баримтлал ба Кластерийн менежмент /2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр/ • Тогтвортой амьжиргааны үзэл баримтлал /2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр/ • Кластерийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, ажиллах зарчим, төслөөс баримталдаг бодлогын баримт бичгийн танилцуулга /2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр/ Ажлын гүйцэтгэл 100%. <p>2. Биологийн олон янз байдлыг хамгаалах зөвлөл болон Мэргэжлийн сэдэвчилсэн ажлын хэсгийн хурлуудыг зохион байгуулах /ҮАТ 4.02/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/65 дугаартай тушаалаар БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулснаар төслийн хүрээнд хэрэгжиж буй зөвлөх үйлчилгээний ажлын явцын болон эцсийн тайланг хэлэлцүүлсэн. Үүнд: ТХГН дахь хог хаягдлын менежментийг сайжруулах, ТХГН-ийн ойн тогтвортой менежментийн суурь судалгаа /2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр/, нийт 2 ажлыг зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан, тайланг хүлээн авсан актуудыг албажуулсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>3. ТХГН-ийн байгаль хамгаалагчдад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлж, хөтөлбөрийг боловсруулах /ҮАТ 4.03/: Ковид 19 цар тахлын хөл хорио, түүнээс шалтгаалан үндэсний зөвлөх ажиллах боломжгүйгээс шалтгаалан тус ажил 2022 он руу шилжсэн. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.</p> <p>4. Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу ТХГН-ийн байгаль хамгаалагчдад зориулсан сургалт явуулах /ҮАТ 4.04/: Ковид 19 цар тахлын хөл хорио, түүнээс шалтгаалан улсын хэмжээнд болон орон нутагт хийхээр төлөвлөсөн сургалт, уулзалтууд хүлээгдэж байна. Олон хүн цуглуулж уулзалт сургалт хийх нь эрсдэлтэй, мөн цахим уулзалт, сургалтын чанар муу байгаа тул төлөвлөсөн сургалт зөвлөгөөн, уулзалтууд хийгдээгүй, 2022 оны үйл ажиллагаа руу шилжсэн. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.</p>
6	<p>Төслийн ерөнхий менежмент</p>	<p>2021 оны үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах ажлын хүрээнд /PM01/: Төслийн удирдах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулан, 2021 оны ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлсний дүнд төслийн 2021 оны үйл ажиллагааны болон ХАА-ны төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр БОАЖЯ-ны ТНБД-аар батлуулсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>“Төслийн 2020, 2021 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх” ажлын хүрээнд /PM02/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/479 дугаартай тушаалаар “Интер аудит” ХХК-тай ҮАГ/АА 2021-171 дугаартай гэрээг 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулсны дүнд аудитын эцсийн тайланг 2021 оны 03 дугаар</p>

	<p>Төслийн ерөнхий менежмент</p>	<p>сарын 31-ний өдөр хүлээн авсан. Аудитын зөвлөмжийн дагуу биелэлтийг гарган ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/207 дугаартай тушаалаар “Төслийн 2021 оны үйл ажиллагаанд аудит хийх” ҮАГ/АА 2021-171С дугаартай гэрээг 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр “Интер аудит” ХХК-тай байгуулсан. Гэрээний дагуу эцсийн тайланг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>Төслийн удирдах хорооны ажлын хүрээнд /PM03/: БОАЖЯ-ны ТХБНУГ-аас төслийн үйл ажиллагаанд 3 ажил нэмж оруулах хэрэгцээ шаардлага гарсан, Ковид19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зарим ажлуудын хугацаа хойшилсонтой холбогдуулан Төслийн удирдах хорооны хурлыг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, асуудлыг хэлэлцсэний дүнд төслийн 2021 оны үйл ажиллагаа болон ХАА-ны төлөвлөгөөг БОАЖЯ-ны ТНБД-аар шинэчлэн тус тус батлуулсан.</p> <p>Төслийн удирдах хорооны ээлжит хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж, 2021 оны үйл ажиллагааны танилцуулан, төслийн 2022 оны үйл ажиллагааны болон ХАА-ны төлөвлөгөөг хэлэлцүүлсэн, төлөвлөгөөг 2021 ондоо багтаан, БОАЖЯ-ны ТНБД-аар батлуулна. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>KfW банкнаас Төслийн явцын үнэлгээний баг ирж ажиллах ажлын хүрээнд /PM04/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Төслийн явцын үнэлгээний KfW банкны баг 2021 оны 05 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд Архангай, Завхан, Ховд, Говь-Алтай, Баянхонгор аймгуудад, тус оны 10 дугаар сарын 11-17-ны өдрүүдэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад, 12 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд Дундговь аймагт тус тус томилолтоор ажиллаж, төслийн I шатны хэрэгжилтийг дүгнэн, II, III шатны үйл ажиллагаа, төсөлд хамрагдсан кластеруудын танилцуулгыг хийж, төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-т хамрагдах ТХГ-ын сонголт, үнэлгээний ажлыг амжилттай зохион байгуулсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>5. Төслийн кластеруудын оролцогч талуудыг хамруулан төслийн бодлого, чиглэл үйл явц, үр дүнг хэлэлцүүлэх, санал авах зөвлөгөөн зохион байгуулах/ PM05/: Цар тахлын дэглэлтийн улмаас хурал, зөвлөгөөний арга хэмжээг зохион байгуулахыг хориглосон учир төслийн кластеруудын оролцогч талуудыг хамруулан төслийн бодлого, чиглэл үйл явц, үр дүнг хэлэлцүүлэх, санал авах зөвлөгөөн зохион байгуулаагүй, цахимаар кластерын менежментийн зөвлөл болон байгаль орчны байгууллагуудын уулзалт, хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>6. Тусгай хамгаалалттай газрын дэд бүтэц (тэмдэг тэмдэглэгээ, нэвтрэх цэг, ажиглалтын цэг, байгаль хамгаалагчийн хувцас хэрэгсэл, БОЯБ-ын нэмэлт хамгааллын асуудал гэх мэт) тоног төхөөрөмжийн стандартыг боловсруулах чиглэлээр талуудын уулзалт зөвлөгөөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх/ PM06/:</p>
--	----------------------------------	--

	<p>Төслийн ерөнхий менежмент</p>	<p>Цар тахлын нөхцөл байдлын улмаас байгаль хамгаалагчийн хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмжийн стандартыг боловсруулах уулзалтуудыг БОАЖЯ-ны ТХБНУГ-ын дарга, холбогдох мэргэжилтэн нарыг байлцуулан 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тус уулзалтаар ТХН, түүний зөвлөх багийн зүгээс ХБНГУ-ын стандартыг танилцуулж, Хан Хэнтийн ДЦГ-ын зүгээс байгаль хамгаалагчийн хувцасны жишээг танилцуулсны дүнд сайдын тушаалаар батлагдах байгаль хамгаалагчийн хувцас хэрэгслийн стандартыг хэлэлцэн тохирсон. ТХГН-ийн байгаль хамгаалагчдыг өвөл, зуны дүрэмт хувцасны стандартыг БОАЖ-ын Сайдын 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/176 тоот тушаалаар батлуулсан. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>7.ТХН-ийн худалдан авах ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны журам боловсруулах, батлуулах /PM07/: Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн худалдан авах ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны журмын төсөл, ажлын даалгаврыг төслийн зөвлөх багтай хамтран боловсруулж байна. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>8. Санхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ /PM07/: Санхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээг ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу гурван хуулийн этгээдээс үнийн саналыг авч БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/139 дугаар тушаалын дагуу Цахим тайлагналын стандарт ХХК-тай гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч байгууллага нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт нийцүүлэн төслийн 2,3 дугаар үе шатны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдах бодлогын баримт бичгийг гэрээний дагуу боловсруулж ТХН, зөвлөх баг, БОАЖЯ-ны СХОҮХ-ээс саналыг авч эцэслэсэн. Ажлын гүйцэтгэл 100%</p>
7	<p>Мониторинг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент</p>	<p>1. Баруун бүсийн СМСТ -ийн барилгад төслийн БОННУ-ний журмын дагуу байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх /M01/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/14 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан. Тайлант хугацаанд Зөвлөх багийн боловсруулсан Баруун бүсийн ССМТ-ийн хөгжлийн концепцийн дагуу Баруун бүсийн төвийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар боловсруулсан. Гэхдээ төслийн хүрээнд баригдах барилга байгууламжуудын зураг төсөл болон ажлын чанар гүйцэтгэлд хяналт тавих зөвлөх багийг сонгон шалгаруулж авсны дараа ББМССТ-ийн барилгын зураг төслийг боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлнэ гэж шийдвэрлэсэн шалтгааны улмаас хүлээгдэж байна. ББССМТ-ийн барилга барих газрыг Ховд аймгийн Засаг даргын шийдвэрээр тодорхойлж өгсөн ба төслийн зөвлөх багийн БОННМБ хариуцсан мэргэжилтэн уг газрын орчинд амьдардаг айл өрх, албан байгууллагуудын зүгээс ямар нэг газрын маргаан байхгүй байгааг судлан тогтоосон. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.</p>

	<p>Мониторинг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент</p>	<p>2. Шинээр баригдах барилгуудад байгаль орчин нийгмийн нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх /M02/: Тус зөвлөх үйлчилгээг Төслийн Зөвлөх баг 2022 оны ХААТ-руу шилжүүлэх шийдвэр гаргасан болно. Тендерүүдийн концепцид нь өөрчлөлт орж байгаа тул энэ онд үнэлгээний хороог байгуулах боломжгүй болсон бөгөөд энэ тухай KfW-д мэдэгдэж Ажлын даалгавар дээр "Үл татгалзах тухай" мэдэгдэл авахаар Төслийн зөвлөх баг ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.</p> <p>3. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн чиглэлээр холбогдох талуудад бүсчилсэн сургалт зохион байгуулах/ M03/: Цар тахлын дэглэлтийн улмаас сургалт арга хэмжээг зохион байгуулахыг түр хугацаанд зогсоосон учир, төлөвлөлт хийгдээгүй болно. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.</p> <p>4. Төслийн байгаль орчин, нийгэм, жендер, ХАБ менежментийн талаар гарын авлага, товхимол боловсруулж, хэвлэж тараах/ M04/: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бодлогын бичиг баримт, гарын авлага, зөвлөмжийг хамтран боловсруулж, санхүүжүүлэгч талын зөвлөхүүдэд хүргүүлэн, батлуулсан. Ажлын гүйцэтгэл 90%.</p> <p>5. Төслийн хяналт үнэлгээний тогтолцоог бий болгож, журмыг боловсруулах/ M05/: Төслийн хяналт үнэлгээний тогтолцоог ажлын даалгавар, концепцийн төслийг төслийн зөвлөх баг боловсруулж, төслийг санхүүжүүлэгч байгууллагад танилцуулсны дүнд 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр зөвшөөрлийг хүлээн авсан. Концепцийн дагуу ажлын даалгаврыг БОАЖЯ-нд танилцуулж, албажуулах, тендерийг 2022 оны 01 дүгээр сард багтаан зарлах болно. Ажлын гүйцэтгэл 100%.</p>
8	<p>Төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн зардал</p>	<p>1. Төсөл хэрэгжүүлэх нэгжид оффисын тавилга, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл нийлүүлэх /5.01/: Нэгжид оффисын тавилга, тоног төхөөрөмж, БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/385 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хорооны 01 дүгээр хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 15-нд зохион байгуулж ажлын даалгавар, тендерийн баримт бичгийн төслийг баталгаажуулсан. Тендерийн зарыг төслийн веб сайт, БОАЖЯ-ны цахим сайт, өдөр тутмын хэвлэл мэдээллийн сонинд 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр зарласан. Тус тендерийн үнэлгээний хорооны 02 дугаар хурал, тендерийн нээлтийг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, гэрээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хамгийн сайн үнэлгээ авч тээврийн хэрэгсэл /Багц 1-д/ шалгарсан "Мөнххада" ХХК-тай тоног төхөөрөмж /Багц 2-т/ шалгарсан "Ай Ти Зон" ХХК-тай тус тус байгуулж, гэрээг 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр дүгнэн, баталгаажуулсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>2. Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн бичиг баримтын мэргэжлийн орчуулга хийлгэх зардал /5.02/: Худалдан авах ажиллагааны зөвлөх үйлчилгээ болон ажлын тендерийн баримт бичгийг боловсруулах ажлыг</p>

		<p>ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу гурван хуулийн этгээдээс үнийн саналыг авч МОН ТАЙ СИНО ГРУПП ХХК-тай нийт 3,136,628 төгрөгөөр гэрээ байгуулж санхүүжилт хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>3.Төсөл хэрэгжүүлэх зөвлөх багийн төлбөр /5.03/ 2021 оны 01 дүгээр сараас 2021 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд төслийн хэрэгжүүлэгч зөвлөх багийн төлбөрт нийт 779,196.24 евро буюу 2,596,555,191.26 төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. Ажлын гүйцэтгэл 100%</p>
9	Тайлан	<p>1.Хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж БОАЖЯ, СЯ-д хүргүүлэх/ R01/:</p> <p>“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хавсралтын дагуу Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар болон 2021 оны хагас жилийн болон эцсийн байдлаар тус тус гаргаж, БОАЖЯ-ны ГХАХ-т хүргүүлсэн.</p> <p>“Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын “Төслийн үнэлгээний тайлангийн загвар”-ын дагуу Төслийн хяналт-шинжилгээний тайланг 2020 оны жилийн эцсийн байдлаар гаргаж, 2021 оны 01 дүгээр сард СЯ-ны ХСГ-т хүргүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>2.Улирал, хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг KfW-д илгээх/ R02/:</p> <p>Төслийн үйл ажиллагааны 01 дүгээр улирал, хагас жилийн тайлан, хяналт шинжилгээ үнэлгээний 01 дүгээр улирлын тайлан, хагас жилийн тайлан, 03 дугаар улирлын тайлан, Санхүүгийн үйл ажиллагаа, ашиглалтын тайлан мэдээг сар бүр БОАЖЯ, СЯ-аар баталгаажуулан KfW-банканд тайлагнасан. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>3.Тусгай дансны татан авалт, зарцуулалтын тайланг KfW банканд илгээх/ R03/:</p> <p>Төслийн тусгай дансны татан авалт, зарцуулалтын тайланг 4 сар тутам KfW банканд хүргүүлж 2021 оны 04 дүгээр сард 103,921.17 евро, 2021 оны 06 дугаар сард 205,000.00 еврог тусгай дансанд тус тус хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>4. Шилэн данс, ODAMIS, www.shilen-dans.mn, E-report, iec.mn, E-tailan-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээх/ R04/:</p> <p>Төслийн үйл ажиллагааны хүрээнд гарсан тушаал, шийдвэрүүдийг шилэн данс, ODAMIS, www.shilen-dans.mn, E-report, iec.mn цахим системүүдэд оруулан бүртгэх. Нэгдсэн тайлан мэдээг тухай бүр E-tailan-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээсэн. Ажлын гүйцэтгэл 100%</p> <p>5. Санхүүгийн ерөнхий тайлан:</p> <ul style="list-style-type: none"> • БОАЖЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс болон Сангийн яаманд төслийн II,III шатны 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг хийж 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр цахимаар илгээж, 2021 оны 08 дугаар сарын

	Тайлан	<p>13-ны өдөр БОАЖ-ны сайдаас Сангийн сайдад албан бичгээр хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> НӨАТ-ын тайланг цаасаар болон цахим хэлбэрээр сар бүр хийж Татварын ерөнхий газарт хүргүүлж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж байна. Хүн амын орлогын албан татварын тайланг сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст хүргүүлж байна. Шилэн дансны тайлан мэдээг сар бүр шинэчлэн хийж, БОАЖЯ-ны дотоод аудит хяналт үнэлгээний газарт улирал бүр нэгтгэн цахимаар илгээж байна. 						
10	Дүгнэлт (ололт, амжилт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололт, амжилт:</p> <ul style="list-style-type: none"> Төслийн II, III үе шатны бодлогын болон үндсэн бичиг баримтыг боловсруулсан <p>Цаашид анхаарах асуудлууд, дутагдал:</p> <ul style="list-style-type: none"> Төслийн I үе шатнаас авсан сургамж дээр анхаарч, алдаа дутагдлыг давтахгүй ажиллах 						
11	Төслийг хэрэгжүүлэгч талуудын х/а-нд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүнд Үндэсний аудитын газраас 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс “Аудитын үйл ажиллагааг эхлүүлэх тухай” шийдвэрээр төслийн I үе шат хэрэгжсэн хугацааг хамруулан төслийн бүхий л үйл ажиллагаанд батлагдсан аудитын төлөвлөгөөний дагуу АГТ-2021/10/ШТА-ГА аудитын кодтой гүйцэтгэлийн аудитыг БОАЖЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай хамтран хийж байна.</p>						
12	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж %	Менежмент 100%	Зорилт 1 30,8%	Зорилт 2 58%	Зорилт 3 35%	Зорилт 4 25%	Мониторинг 38%
Нийт 7 ажлаас 7 ажил-100%			Нийт 13 ажлаас 2 ажил-100% 1 ажил-70% 2 ажил-50% 5 ажил-20% 2 ажил-хугацаа хойшилсон	Нийт 5 ажлаас 2 ажил-70% 3 ажил-50%	Нийт 2 ажлаас 1 ажил-70% 1 ажил-хугацаа хойшилсон	Нийт 4 ажлаас 2 ажил-100% 2 ажил-хугацаа хойшилсон	Нийт 5 ажлаас 1 ажил 100% 1 ажил 90% 3 ажил-хугацаа хойшилсон	

			1 ажил цуцлаг дсан				
		<p>Нийт 2021 онд төлөвлөсөн ажил: 36 ажил. Үүнээс: 1 ажил цуцлагдсан тул үнэлээгүй. Үүнд: Бурхан Халдун хайрхны орчны бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын загвар төсөл хэрэгжүүлэх /ҮАТ 1.13./ ажил төслийн удирдах хорооны хурлаар цуцлахаар шийдвэрлэсэн. Үнэлсэн: 35 ажил. 100%-тай=12=1200 /бүрэн хэрэгжиж дууссан/ 90%-тай = 1=90 /ажил хүлээн авах шатандаа/ 70%-тай = 4=280 /гэрээ хэрэгжих шатандаа/ 50%-тай =5=250 /гэрээ хэрэгжих шатандаа/ 20%-тай = 5=100 /гэрээ байгуулагдах шатандаа/ 8 ажил хугацаа хойшилсон.</p>					
		Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 2021 оны байдлаар 54,9 % -тай байна.					
13	ЗГХЭГ-ын үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ					
		... %					
Нэмэлт мэдээлэл /сая төгрөгөөр/							
14	Зарцуулалт	2019	2020	2021			
	ХБНГУ-ын Засгийн газар		2,257.18₮	3,533.03₮			
	МУ-ын Засгийн газар	52.09 ₮	546.71 ₮	697.07₮			
15	Жендерийн мэдээлэл	Тус төсөл нь санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа төсөл бөгөөд цар тахлын улмаас 2021-нд төлөвлөсөн чадавхийг бэхжүүлэх сургалт, арга хэмжээнүүд хойшилсон хэдий ч цаашид зохион байгуулагдахад жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллана.					
16	Суурь судалгаа хийгдсэн эсэх	УТХГ-ын ойн суурь судалгааг 2021 оны IV улиралд баруун 3 аймгийн 10 суманд хийж, тайланг хүлээн авсан. /ҮАТ 1.03./					

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН- 2021.12.31**

	Тайлант хугацаа 2021.12.31		Өссөн дүнгээр	
	евро	төгрөгөөр	евро	төгрөгөөр
Орлого				
КМВ				
Шууд санхүүжилт (Зөвлөх)	779,196.24	2,596,555,191.26	1,367,832.09	4,526,459,051.76
Хялбаршуулсан шууд санхүүжилт	-	-	-	-
Татан төвлөрүүлэлтийн данс	308,921.17	1,050,701,168.93	408,921.17	1,377,976,168.93
КМВ-орсон нийт санхүүжилт	1,088,117.41	3,647,256,360.19	1,776,753.26	5,904,435,220.69
Хүүгийн орлого	-	-	-	-
МУЗГ				
Төрийн сан	216,990.42	735,545,800.00	425,575.11	1,404,950,200.00
Нийт санхүүжилт/Орлого	1,305,107.83	4,382,802,160.19	2,202,328.37	7,309,385,420.69
Зардал				
КМВ				
КМВ	1,012,266.15	3,353,027,407.88	1,604,823.17	5,296,390,177.50
МУЗГ	205,305.05	697,066,566.54	393,477.82	1,296,007,816.18
МУЗГ-т буцаан шилжүүлсэн	11,685.37	38,479,233.46	32,097.30	108,942,383.82
Гадаад ханшийн зерүү	-	75,970,443.88	-	53,916,082.42
Нийт зардал	1,229,256.57	4,164,543,651.76	2,030,398.28	6,755,256,459.92
Үр дүн	75,851.26	218,258,508.43	171,930.09	554,128,960.77
Урьдчилгаа	-	-	-	-
Цэвэр мөнгөн хөрөнгө	75,851.26	218,258,508.43	171,930.09	554,128,960.77
Эхний үлдэгдэл				
КМВ				
Тусгай данс	96,078.83	335,870,452.34	-	-
дэд данс	-	-	-	-
КМВ-ийн нийлбэр	96,078.83	335,870,452.34		
МУЗГ	-	-	-	-
Төрийн сан	-	-	-	-
Эхний үлдэгдлийн нийлбэр	96,078.83	335,870,452.34		
Эцсийн үлдэгдэл	171,930.09	554,128,960.77	171,930.09	554,128,960.77
КМВ				
Тусгай данс	171,930.09	554,128,960.77	171,930.09	554,128,960.77
дэд данс	-	-	-	-
КМВ-ийн эцсийн үлдэгдлийн нийлбэр	171,930.09	554,128,960.77	171,930.09	554,128,960.77
МУЗГ	-	-	-	-
Төрийн сан	-	-	-	-
Эцсийн үлдэгдлийн нийлбэр	171,930.09	554,128,960.77	171,930.09	554,128,960.77


ХЯНАСАН:

ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН


 Г.ЭРДЭНЭБАЯСГАЛАН
 1119278525 60085084

Д.БАТМӨНХ

Г.ЭРДЭНЭБАЯСГАЛАН

Ц.ЭНХСАЙХАН

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
нийтлэг журмын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ
ТУСЛАМЖААР ХЭРЭГГИЖ БҮЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

№	Төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	<p>“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” I төсөл Шийдвэр: 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улс- ХБНГУ Засгийн газар хоорондын байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр болон Төслийн хэрэгжилтийг сунгах тухай 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн шийдвэр Төслийн дугаар: BMZ 2012 65 511-I шат Төслийн зорилго: Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг (орчны бүс болон экологийн коридорыг) бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.</p>			
2	Санхүүжилт-ийн эх үүсвэр	ХБНГУ-ын Засгийн газар - Буцалтгүй тусламж Монгол Улсын Засгийн газар			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх баг			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, БОАЖЯ-ны ТХБНУГ, ТХГН-ийн хамгаалалтын захиргаад			
		Хэрэгжих хугацаа: 6 жил 7 сар: 2015.05.01 - 2021.12.31 /I шат/			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1: Тусгай хамгаалалттай газар нутгууд /ТХГН/ болон тэдгээрийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, төслийн бэлтгэл хангах, Зорилт 2: ТХГН-ийн батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Зорилт 3: Үндэсний болон бүсийн түвшинд ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх, Зорилт 4: Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа.</p>			
5	Зардал	Төслийн I үе шатны нийт төсөв 15.3 сая евро. ХБНГУ-ын Засгийн газар 11.5 сая евро, Монгол Улсын Засгийн Газар 6.65 тэрбум төгрөг.			
		Төсөв (2021 он)	Гүйцэтгэл		Хувь
		ХБНГУ-ын Засгийн газар	7,213,150,000 төгрөг	2,167,880.15 евро	7,205,702,588.02 төгрөг

6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	2021 оны Үйл ажиллагааны /2021.05.24-ний өдөр / шинэчилсэн төлөвлөгөөний дагуу биелэлтийг гаргав.
	<p>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газар нутгууд болон тэдгээрийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, төслийн бэлтгэл хангах</p>	<p>1. Тусгай хамгаалалттай газар нутаг, төслийн танилцуулга хэвлэх /ҮАТ 1.01/: Төслийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийг иргэдэд хүргэх зорилготой кластерийн сумуудаар тойрч, уулзалт мэдээлэл хийх үед зориулан хэвлэж нийлүүлэх ажлын гэрээг “Ай Ти Ворк” ХХК-тай 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсны дагуу төслийн 500ш танилцуулга, 500ш календарь, 500ш нэрийн хуудас нийт 855,000,000.00 төгрөгийн материалыг хэвлэж, Орчны бүсийн нийт 40 сумдад төслийг сурталчлах тарааж ашигласан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>2. Баригдсан барилга байгууламжуудад байгаль орчны үнэлгээ хийх /ҮАТ 1.02/: Төслийн 1 дүгээр үе шат дуусах гэж байгаатай холбогдуулж, төлөвлөсөн ажлуудаас нэн яаралтай буюу улирлын чанартай нэр бүхий 18 тендерийг богино хугацаанд зохион байгуулах зорилгоор Сэргээн босголт, Зээлийн банк (KfW)-ны “Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам”-ын 2.1.5-д заасан € 20,000.00 доош үнийн дүн бүхий ХАА-г гэрээ шууд байгуулах аргаар хийхээр хэлэлцсэн. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Гэрээ шууд байгуулах удирдамж, Сэргээн босголтын Зээлийн банк (KfW)-наас 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр гэрээ шууд байгуулах ажлыг зөвшөөрсөн ерөнхий “Үл татгалзах тухай мэдэгдэл”, Сэргээн босголтын Зээлийн банк (KfW)-наас 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр гэрээ шууд байгуулах ажлыг зөвшөөрсөн тусгайлсан “Үл татгалзах тухай мэдэгдэлд тус тус үндэслэн БОАЖЯ-ны ТНБД-ын “Гэрээ шууд байгуулах ажлын жагсаалт батлах тухай” 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/54 дугаар тушаалаар тус тус баталгаажуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/53 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/154 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Үнэт байгаль” ХХК-тай ГШБ-1/0821, 21/191 дугаартай 70,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн тайланг тус яамны БОУАХ-ээр 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хэлэлцэж, ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. Тус яамны холбогдох хэлтсээс ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 95%.</p> <p>3. Хустай нурууны БЦГ-ын байгаль хамгаалагч, судлаачдын байрны холбогдох нэмэлт ажил /ҮАТ 1.03/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/53 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/154 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Донж авто суудал” ХХК-тай ГШБ-1/1621, дугаартай 43,521,282.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдөр байгуулж ажилласны дүнд Төв аймгийн Аргалант суманд баригдсан “Хустайн цогцолборт газар төв” ТББ-ын “Байгаль хамгаалагчид, судлаачдын байрны барилгын нэмэлт ажил, засварын ажил”-ыг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 21-нд ажиллуулж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар</p>

		<p>шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллага нь биелэлтийг Газрын харилцаа, БХТ-өөр баталгаажуулж, 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр ирүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100%.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх</p>		<p>1. Дэд төслийн хүрээнд баригдсан ХЗ, СМТ, байгаль хамгаалагчийн байруудыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.01/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/53 дугаартай “Хөрөнгө зарцуулах тухай” тушаалаар MON/ICB019/2019 дугаартай € 286,624.00 үнийн дүн бүхий ажлын гэрээг “Ай Ти Зон” ХХК-тай тус оны 05 дугаар сарын 13-ны өдөр байгуулж ажилласны дүнд гүйцэтгэгчийн нийлүүлэх нийт 575 ширхэг тоног төхөөрөмжийн 97 хувь нь агуулахад хүрэлцэн ирсэн, Хонда маркийн 20 ш моторын нийлүүлэлт /Ковид 19/ цар тахлын нөхцөл байдлын улмаас хил хаагдсантай холбогдуулан хойшилсон. Тоног төхөөрөмжийг хүлээн авахаар бараа хүлээлцэх акт, гэрээ дүгнэх актын төслийг гүйцэтгэгчид хүргүүлж бэлтгэл ажлыг хангаад байна. 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр дуусах тус гэрээний хэрэгжилтийг эхний улиралд багтан дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 95%. Энэхүү ажлын дүнд УТХГ-ын ХЗ-ны менежментийг сайжруулах зорилгоор 2018-2020 онуудад төслийн хүрээнд баригдсан Хангайн бүсийн төв, 1ХЗ, 5 СМТ болон 47 байгаль хамгаалагчийн байруудыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах дэд төсөлд хамрагдсан нийт 11 ХЗ, СМТ, байгаль хамгаалагчийн байруудыг компьютер, тоног төхөөрөмжөөр тус тус бүрэн хангана.</p> <p>2. Зэд Хантай Бүтээлийн нурууны ДЦГ, Онон Балжийн БЦГ, Хорго тэрхийн цагаан нуурын БЦГ-ын орчны бүсийн ард иргэдийн амьжиргааг дэмжих үйл ажиллагааны ажлын хүрээнд /ҮАТ 2.02/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/254 дугаартай тушаалаар тус ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/386 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Дугант бар” ХХК-тай ҮТА-№10-2020 дугаартай 520,496,840.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулж ажилласны дүнд Хорго-Тэрхийн Цагаан нуурын БЦГ-ын жуулчдад үйлчлэх шинэ цэг байгуулж, байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдөр ажиллуулж, худалдааны цэгийг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Мөн Зэд Хантай бүтээлийн нурууны ДЦГ-ын ХЗ-нд төмс, хүнсний ногооны 40 тонны зорь, дагалдах хэрэгслийн хамт, 120 м²-ийн нийлэг хальсан хүлэмж-3 ширхэг (тус бүр дуслын усалгааны системтэй)-ийг хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ажиллуулж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллага нь биелэлтийг Газрын харилцаа, зургийн зохиогчоор баталгаажуулж, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн. 2021 онд багтаан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>3. Орчны бүсийн ард иргэдийн амьжиргааг дэмжих тоног төхөөрөмжөөр хангах /Отгонтэнгэр УТХГ Дорнод УТХГ болон Хангайн нурууны БЦГ хамгаалалтын захиргаа/ /ҮАТ 2.03/: Төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд УТХГ-ын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/72 дугаартай тушаалаар “Орчны бүсийн ард иргэдийн амьжиргааг дэмжих тоног төхөөрөмжөөр хангах” ажлын</p>

2-р зорилтын хүрээнд:
Хүрэх үр дүн:
Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх

гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/171 дугаартай тушаалаар тендерийн ялагч “МБ Инжиниринг” ХХК-тай 01-05/21, 21/199 дугаартай 643,228.700.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийн захиалгыг бүрэн хийсэн бөгөөд анжис, үр будаа ариутгагч агуулахад ирсэн, үрлэгч, хаман боогч нь агуулахад хүрэлцэн ирсэн, трактор, тэжээл бутлагч, чиргүүл үйлдвэрлэгдэх шатандаа байна. Гэрээний хугацаа 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр, 2022 эхний улиралд багтан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 70%. Энэхүү ажлын дүнд орчны бүсийн иргэд байгалийн хадлан бэлтгэх, тариалангийн аж ахуй эрхлэх, илүүдлийг зах зээлд борлуулж, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилготой.

4. Орчны бүсийн сангийн үйл ажиллагааг дэмжиж техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх /ҮАТ 2.04/:

Төслийн хүрээнд ТХГН-ийн Орчны бүсэд нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зээлийн эргэлтийн сангийн журмыг 2017 онд “Бодлого судлалын төв” ТББ боловсруулсны дагуу орчны бүсийн малчид, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, бэлчээрийн даацад сөрөг нөлөө үзүүлж буй малын тоог бууруулах зорилгоор арилжааны банкны хүүгийн түвшнээс бага хувийн хүүтэй зээл олгох бэлтгэл ажлын хүрээнд сонгогдсон сумдад газар дээр нь уулзалт, сургалт зохион байгуулах ажлын гэрээг өмнөх байгууллагатай шууд байгуулах зөвшөөрлийг 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр KfW банкнаас хүлээн авсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/142 дугаартай тушаалаар “Бодлого судлалын төв” ТББ-тай CS-01/0921 дугаартай € 50,000.00 үнийн дүн бүхий ажлын гэрээг 2021 оны 08 дугаар 15-ны өдөр байгуулан ажилласны дүнд эцсийн тайланг хүлээн аваад байна. 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр дуусах гэрээний дагуу тус ажлын тайланг 2022 онд багтаан төслийн БОЯБ-ын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 95%.

5. Дэд төслийн хүрээнд хамгаалалтын захиргаадыг бусад тээврийн хэрэгслээр хангах Багц 2: хогны машин, бохир соруулдаг машин /ҮАТ 2.05/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/345 дугаартай тушаалаар тус тендерийн үнэлгээний хороог шинэчлэн байгуулсны дагуу тендерийг KfW банкны ХАА-ны журам болон ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. Тендерийн үнэлгээний хорооны тайланг KfW банканд хүргүүлсний дүнд зөвшөөрлийг 2021 оны 03 дугаар сарын 18-ний өдөр хүлээн авсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/251 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Еврохан” ХХК-тай MON/ICB01/2020 болон 21/271 дугаартай € 198,000.00 үнийн дүн бүхий ажлын гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байгуулан ажилласны дүнд тээврийн хэрэгслийн захиалгыг бүрэн хийсэн. 2 ширхэг контейнерээс бусад тээврийн хэрэгсэл үйлдвэрлэлийн шатандаа байна. Гэрээний хүрээнд хогны машин, контейнерын хамт 4 ширхэг, нэмэлт контейнер 5 ширхэг, бохир соруулдаг машин 2 ширхгийг Горхи Тэрэлжийн БЦГ, Отгонтэнгэрийн УТХГ, Орхоны Хөндийн БЦГ, Хангайн нурууны БЦГ-уудын ХЗ-дад хүлээлгэн өгөх гэрээний хугацаа 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр дуусах гэрээний дагуу тус ажлын тайланг 2022 онд багтаан төслийн БОЯБ-ын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 50%.

<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх</p>	<p>6. Дэд төслийн хүрээнд хамгаалалтын захиргаадыг бусад тээврийн хэрэгслээр хангах Багц 1: бага оврын автобус, зөөврийн чингэлэг /ҮАТ 2.06/: Тус ажлыг “Дэд төслийн хүрээнд хамгаалалтын захиргаадыг бусад тээврийн хэрэгслээр хангах” ҮАТ 2.05/-ын ажилтай нэгтгэн багцалж, тендерийг 2020 оны 07 дугаар сард зарласан хэдий ч тендер ирээгүй тул зөөврийн чингэлгийг стандарт бус үндэслэлээр ажлын даалгавраас хасаж, дахин зарлах зөвшөөрлийг 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр KfW банкнаас ирүүлсний дагуу тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу дахин зохион байгуулсан. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/191 дугаартай тушаалаар №01-03/21 дугаартай 336,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ажлын гэрээг “УАЗ Мега” ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулж ажилласны дүнд нийт 7 фургон машины захиалгыг хийснээс 4 нь Улаанбаатар хотын агуулахад 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр ирсэн. Дорнод, Отгонтэнгэрийн УТХГ, Хустай, Хангайн нуруу, Зэд Хантай бүтээлийн нуруу, Тарвагатай нуруу, Онон Балжийн БЦГ-ны ХЗ-дад 2022 оны I улиралд багтаан хүлээлгэн өгнө. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 70%. Энэхүү ажлын дүнд дэд төсөлд хамрагдсан УТХГ-т фургон машин нийлүүлснээр ХЗ-ны судалгаа шинжилгээ, хяналт мониторингийн үйл ажиллагаа сайжирна.</p> <p>7. Дэд төслийн хүрээнд баригдсан ХЗ болон СМТ-ийн байрны АЦБ-ийн ажилд зөвлөхийн дэмжлэгтэйгээр хяналт тавих ажлын хүрээнд /ҮАТ 2.07/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/500 дугаартай тушаалаар “ЭнЭйПи Групп” ХХК-тай Хан Хэнтий, Улаантайга, Отгонтэнгэрийн УТХГ, Онон Балж, Тарвагатай нурууны БЦГ-уудын хамгаалалтын захиргааны байр, Сургалт мэдээллийн төвийн 6 барилгын АЦБ-ийн зураг төсөв боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ҮТ08-2019 дугаартай 123,670,700.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу 5 барилгын ариун цэврийн байгууламжийн шийдлийн судалгаа бүхий ажлын тайлангийн зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөр батлуулж, 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр, Тарвагатай нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны АЦБ-ийн барилгын ажлын даалгаварт өөрчлөлт орсонтой холбогдуулан зураг төслийг шинэчлэн, 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр тус тус хүлээлгэн өгснөөр нийт 6 барилгын АЦБ-ийн ажлын зургийг хүлээлгэн өгч дууссан. Гэрээний дагуу хамгаалалтын захиргаа болон сургалт мэдээллийн төвийн байранд боловсон ОО барих барилгын ажлыг дуустал ажлын даалгавар, техникийн үзүүлэлт, зураг төслийн дагуу гүйцэтгэх гэрээлэгч нарын ажилд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тарвагатай нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны АЦБ-ийн барилгын ажил он дамжиж хийгдэж байгаатай холбогдуулан тус барилгад хяналт тавьснаар гэрээт ажил дуусах тул гэрээний хугацааг 2022 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хүртэл сунгасан. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 90%</p> <p>8. Дэд төслийн хүрээнд баригдсан Тарвагатайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны барилгын өргөтгөлийн АЦБ барих /ҮАТ 2.08/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/55 дугаартай тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулж, урилгыг 3 компанид хүргүүлсэн хэдий ч санал ирээгүй тул барилгын ажлын төсвийг барилгын материалын зах зээлийн ханш, барилгын ажлын төсөв тооцох шинэчилсэн аргачлалын</p>
---	---

дагуу дахин тооцож, тендерийг дахин зарлахаар шийдвэрлэсэн. Тендерийн баримт бичиг, ажлын даалгаврыг захиалагчаар шинэчлэн батлуулж, тендерийг 2022 онд зарлахаар шилжүүлсэн. Ажлын гүйцэтгэл хугацаа хойшилсон.

9. Дэд төслийн хүрээнд баригдсан 4 сургалт мэдээллийн төвийн байранд ариун цэврийн байгууламж барих /ҮАТ 2.09/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/256 дугаартай тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсны дүнд АЦБ-ийн барилгуудын ажлын гүйцэтгэл дунджаар **95%-тай** байна. Энэхүү ажлын дүнд УТХГ-ын Хан Хэнтий, Отгонтэнгэр болон Улаан Тайга, Тарвагатайн нурууны БЦГ-ын ХЗ-ны мэргэжилтэн, ажилтан нарын ажиллах нөхцөл сайжирсан. Үүнд:

Багц 1. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 19-ний А/330 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Агар эрдэнэс трейд” ХХК-тай “Улаантайгын УТХГ-Хөвсгөл аймгийн Улаан уул сум дахь сургалт мэдээллийн төвийн барилгын өргөлт, ариун цэврийн байгууламж барих” ҮТА№07-04/2020 дугаартай 107,161,209.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Хөвсгөл аймгийн Улаан Уул суманд баригдсан Улаан Тайгын УТХГ-ын ХЗ-ны сургалт мэдээллийн төвийн ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ажиллуулсны дүнд үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллага нь биелэлтийг Газрын харилцаа, зургийн зохиогчоор баталгаажуулж, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн. 2021 онд багтаан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 95%.

Багц 2. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/332 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Нью Урбанизм” ХХК-тай “Тарвагатайн нурууны БЦГ-ын ХЗ-ны сургалт мэдээллийн төвийн байрны АЦБ барих” ҮТА№07-01/2020 дугаартай 99,092,083.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Архангай аймгийн Цахир суманд баригдсан Тарвагатайн нурууны БЦГ-ын ХЗ-ны сургалт мэдээллийн төвийн ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 07 дугаар сарын 28-нд ажиллуулж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллага нь биелэлтийг Газрын харилцаа, зургийн зохиогчоор баталгаажуулж, 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн. 2021 онд багтаан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 95%.

Багц 3. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/401 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Нью Урбанизм” ХХК-тай “Хан Хэнтий болон Отгонтэнгэрийн УТХГ-ын ХЗ-ны сургалт мэдээллийн төвийн байрны АЦБ барих” ҮТА№07-02/2020 дугаартай 99,279,518.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд баригдсан Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны сургалт мэдээллийн төвийн ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр, Завхан аймгийн Отгон сумд баригдсан Отгонтэнгэрийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны сургалт мэдээллийн төвийн ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр тус тус ажиллуулж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллага нь биелэлтийг Газрын харилцаа, зургийн зохиогчоор

2-р зорилтын хүрээнд:
Хүрэх үр дүн:
Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх

баталгаажуулж, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн. 2021 онд багтаан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 95%.

10. Дэд төслийн хүрээнд баригдсан Багц 1: 1 сургалт мэдээллийн төвийн байранд ариун цэврийн байгууламж барих, 10 байгаль хамгаалагчдын байранд эко 00 барих, Багц 2: 36 байгаль хамгаалагчдын байранд эко 00 барих /ҮАТ 2.10/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/256 дугаартай тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу явуулсны дүнд доорх ажлын гүйцэтгэл дунджаар **98%-тай** байна. Энэхүү ажлын дүнд УТХГ-ын ХЗ-ны мэргэжилтэн, ажилтан нарын ажиллах нөхцөл сайжирсан.

Багц 1: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 19-ний А/331 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Ангараг Од” ХХК-тай “Хэнтий аймгийн Дадал суманд баригдсан СМТ-ийн барилгад ариун цэврийн байгууламж барих, байгаль хамгаалагчийн 10 байранд эко 00 барих” ҮТА№08-01/2020 дугаартай 297,170,616.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Хэнтий аймгийн Дадал суманд баригдсан Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргааны сургалт мэдээллийн төвийн ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ажиллуулсны дүнд үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу биелэлтийг Газрын харилцаа, зургийн зохиогчоор баталгаажуулж, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн. 2021 онд багтаан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 95%.

Багц 2: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/329 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Дуулгат мөрөн” ХХК-тай “Дэд төсөлд багтсан ТХГН-ийн ХЗ-ны байгаль хамгаалагчийн байрны АЦБ-ийг барих” ҮТА№08-02/2020 дугаартай 202,094,475.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. УТХГ-ын Тарвагатайн нурууны БЦГ- Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Цагаан хясаа, Тэгшийн Цахирын цагаан гүвээ, Архангай аймгийн Цахир сумын Хөх нуурын ам, Улаанхаалга, Ногоон нуур, Туна – Ходоод нуур, Ямаат, Мухарт, Отгонтэнгэрийн УТХГ-Богдын гол, Улаан тайга УТХГ- Улаан-Уул сумын Дотормош, Хорон тал, Рэнчинлхүмбэ сумын Эмгэний хаш, Баянзүрх сумын Дэлгэрмөрөн, Хулгана голын бэлчир, Рэнчинлхүмбэ сумын Хогорын Хар даваа, Тэнгис-Шишгэдийн бэлчир, Хангайн нуруу БЦГ- Овоот, Ноён хангайн рашаан, Чулуут сумын Даваат, Ихтамир сумын Хөхнуур багийн төв, Булган сумын Чандманы ам, Цэнхэр сумын Ширдэгийн гол, Орхоны хөндийн БЦГ- Архангай аймгийн Хашаат сумын Цайдам, Хотонт сумын Тэмээ хүзүү, Бат-Өлзий сумын Төвхөн, Улаан цутгалан, Цагаан голын гүүр, Хөгнө Тарна БЦГ- Өвөрхангай аймгийн Бүрд сумын Баян түрүү, Булган аймгийн Рашаант сумын Элсэн тасархай, Босого, Гурван булаг сумын Ооно, Зэд хантай бүтээлийн нуруу ДЦГ- Булган аймгийн Сэлэнгэ сумын Цүүцийн баруун салаа, Хайлантай баруун голын Хуст хөндий, Шаварын гол Альбертын урд энгэр, Тариахтайн дээд гүүр, Тэшиг сумын Эг Тарвагатайн голуудын бэлчир, Эрэн цаламын Артилийн улаан мод зэрэг газруудад баригдсан ХЗ-ны 36 байгаль хамгаалагчдын байрны АЦБ-ыг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100%.

11. “Орчны бүсийн сумдын Эргэлтийн сангийн зээлийн ажлыг санхүүжүүлэх” ажлын хүрээнд /ҮАТ 2.11./:

Төслийн хүрээнд 2019 онд боловсруулсан “Орчны бүсийн сангийн журам, удирдамж, гэрээний загвар, бусад дагалдах бичиг баримтууд”-ын дагуу

2-р зорилтын хүрээнд:
Хүрэх үр дүн:
Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх

2-р зорилтын хүрээнд:
Хүрэх үр дүн:
Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Орчны бүсийн иргэдэд “Төрийн банк”-аар дамжуулан зээл олгох ажлын гэрээг 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр “Бодлого судлалын төв” ХХК -тай гэрээ байгуулсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/188 дугаартай тушаалаар дэд төсөл хэрэгжиж буй ТХГН-ийн орчны бүсийн сумдын иргэдэд хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээ үзүүлж, өрхийн орлогыг малын бус гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зээлээр дэмжих зээлийн эргэлтийн санд € 430,000.00 буюу 1,437,709,300.00 төгрөгийн үнийн дүн бүхий санхүүжилтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр шилжүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100%.

Энэхүү ажлын хүрээнд гүйцэтгэгч Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн танилцуулгыг 5 сумын нийт гаруй 900 хүнийг оролцуулан хийж, үүнээс 166 малчин өрх нийт 1.4 тэрбум гаруй төгрөгийн зээлийг авсан байна. Ингэснээр ТХГН-ийн Орчны бүсийн малчид, иргэдийн амьжиргааг дэмжих, бэлчээрийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээх, малын чанарыг сайжруулж, тоо толгойг 10%-аар бууруулах юм. Хэрэгжилтийн тайланг 2 сар тутам хүргүүлж байгаа бөгөөд 2021 оны 11 сарын 15-ны өдрийн байдлаар нийт 166 зээлдэгч 1,431,811,860 төгрөгийн зээлийг олгоод байна.

12. Дэд төсөлд хамрагдсан ТХГН-т нэвтрэх хаалга, отоглох хоноглох цэгийг байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 2.12/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/255 дугаартай тушаалаар "ТХГН-т нэвтрэх хаалга, отоглох хоноглох цэгийг байгуулах" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/352 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Баядах өргөө” ХХК-тай ҮТА№09/2020 дугаартай 512,326,141.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг тус өдөр байгуулсан. Гэрээний заалтын дагуу гүйцэтгэгч компани нь Горхи-Тэрэлжийн БЦГ- Улаанбаатар хотын Налайх дүүргийн Чингис хад, Сайханы саравч, Хорго-Тэрхийн Цагаан нуурын БЦГ- Архангай аймгийн, Тариат сум, Отгонтэнгэрийн ДЦГ-Завхан аймгийн Алдархаан сумын Даян, Тарвагатайн нурууны БЦГ- Архангай аймгийн Цахир сумын Хөх нуурын ам, Орхоны хөндийн БЦГ- Өвөрхангай аймгийн Уянга сумын Ширээт нуур, Бат-Өлзий сумын Хойд агуйт, Дорнодын УТХГ–Дорнод аймгийн Чулуунхороот сумын Галуут нуур, Дашбалбар сумын Чух нуур, Онон-Балжийн БЦГ-Хэнтий аймгийн Дадал сумын Агацын гол, Хан Хэнтийн УТХГ-Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хонин нуга цэгт нийт 11 отоглох хоноглох цэгийг Хөгнө-Тарны БЦГ-Булган аймаг, Рашаант сум, Элсэн тасархай, Хорго-Тэрхийн Цагаан нуурын БЦГ-Архангай аймгийн Тариат сумын Суман голын гүүр, Тарвагатайн нурууны БЦГ-Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Идэр голын гүүр, Орхоны хөндийн БЦГ-Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Хүрхрээ болон Төвхөн, Хархорин сумын Орхон, Хужирт сумын Үүртийн тохой, Уянга сумын Найман нуур зэрэг 8 газарт автомат нэвтрэх хаалгыг байрлуулж тохижуулах ажлын зураг төслийг захиалагч талаар батлуулж, батлагдсан зураг төслийн дагуу төвлөрсөн болон бие даасан ариутгах татуургын системд холбох боломжгүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын ахуйн хэрэгцээнд хэрэглэх зориулалттай нүхэн жорлон, угаадасны нүхний зураг төсөл зохиох, барьж ашиглах, хяналт тавихад мөрдөх MNS: 5924 стандартын дагуу 9 газарт отоглох хоноглох цэг, 8 цэгт автомат хаалга байрлуулах ажлуудыг иж бүрдлийн дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100%.

13. Дэд төслийн хүрээнд Хустайн нурууны БЦГ-т 3 фазын нөөцийн цахилгаан үүсгүүр болон автомат сэлгэн залгагч нийлүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 2.13/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/132 дугаартай тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны ХАА-ны журам болон

<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх</p>	<p>ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дугаартай тушаалаар УТ№01/2020 дугаартай 126,225,891.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг “Констракшн инженеринг энд консалтинг сэрвис” ХХК-тай 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр байгуулж ажилласны дүнд Хустайн БЦГ-ын ХЗ-нд 3 фазын нөөцийн цахилгаан үүсгүүр болон автомат сэлгэн залгагчийг 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгч, суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>14. “Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах” ажлын хүрээнд /ҮАТ 2.14/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/409 дугаартай тушаалаар 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр € 140,000.00 үнийн дүн бүхий гэрээг байгуулж ажилласны дүнд Отгонтэнгэрийн УТХГ, Зэд хантай бүтээлийн нурууны БЦГ, Тарвагатайн нурууны БЦГ, Хангайн нурууны БЦГ, Орхоны хөндий БЦГ, Онон Балжийн БЦГ, Улаан тайгын УТХГ, Горхи Тэрэлжийн БЦГ, Хустайн БЦГ, Дорнод Монголын УТХГ, Хан-Хэнтийн УТХГ нийт 11 УТХГ-ын хамгаалалтын захиргааны орчны бүсийн 48 суманд эко кабинет бий болгож, сургууль тус бүрд 4 төрлийн 4 компьютер техник хэрэгслийг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр бүрэн хүлээлгэн өгсөн. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>15. “Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг тавилга, тоног төхөөрөмжөөр хангах” ажлын хүрээнд /ҮАТ 2.15/: Тус ажлыг “Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах” /ҮАТ 2.16/-ын ажилтай нэгтгэн багцалж, тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/408 дугаартай тушаалаар “Хасу Энержи Интэрнэшнл” ХХК-тай 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр € 169,920.00 үнийн дүн бүхий гэрээг байгуулж ажилласны дүнд Отгонтэнгэрийн УТХГ, Зэд хантай бүтээлийн нурууны БЦГ, Тарвагатайн нурууны БЦГ, Хангайн нурууны БЦГ, Орхоны хөндий БЦГ, Онон Балжийн БЦГ, Улаан тайгын УТХГ, Горхи Тэрэлжийн БЦГ, Хустайн БЦГ, Дорнод Монголын УТХГ, Хан-Хэнтийн УТХГ нийт 11 УТХГ-ын орчны бүсийн 48 суманд эко кабинет бий болгож, сургууль тус бүрд 9 төрлийн 72 ширхэг тавилга тоног төхөөрөмжийг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр бүрэн хүлээлгэн өгсөн. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>16. Дэд төслийн хүрээнд ХЗ-дыг хогны машин, завь, UTV болон цасны мотоцикл зэрэг тээврийн хэрэгслээр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.16/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/272 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Протек” ХХК-тай MON/ICB014/2019 дугаартай € 369,103.70 үнийн дүн бүхий ажлын гэрээг 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу УТХГ-ын Зэд хантай бүтээлийн нурууны ДЦГ, Отгонтэнгэр УТХГ, Хангайн нурууны БЦГ, Горхи Тэрэлжийн БЦГ, Дорнод Монгол УТХГ, Онон Балжийн БЦГ, Хан Хэнтийн УТХГ, Богд Хан уулын ДЦГ зэрэг нийт 8 ХЗ-нд UTV, цасны мотоцикл, завь, хогны машин зэрэг 4 төрлийн 23 ширхэг тээврийн хэрэгсэл, хогны машины чингэлэг 2, хамгаалалтын дуулга 13, бээлий 13, нүдний шил 13, аврах хантааз 56 зэрэг нийт 97 ширхэг хэрэгслийг дагалдуулж бүрэн нийлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100%.</p>
---	--

	<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх</p>	<p>17. “Эко кабинетыг сургалт, судалгааны багаж, хэрэгслээр хангаж, багш нарыг чадавхжуулах” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.17/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/251 дугаартай тушаалаар зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан, сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/360 дугаартай тушаалаар 557,704,650.00 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-05/2020 дугаартай гэрээг “Байгаль орчны сургалт мэдээллийн төв” ТББ-тэй 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр байгуулж ажилласны дүнд Отгонтэнгэрийн УТХГ, Зэд хантай бүтээлийн нурууны БЦГ, Тарвагатайн нурууны БЦГ, Хангайн нурууны БЦГ, Орхоны хөндий БЦГ, Онон Балжийн БЦГ, Улаан тайгын УТХГ, Горхи Тэрэлжийн БЦГ, Хустайн БЦГ, Дорнод Монголын УТХГ, Хан-Хэнтийн УТХГ-ын нийт 11 УТХГ-ын орчны бүсийн 48 сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад, мөн хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүдэд орон нутгийнхаа байгалийн болон соёлын өв, нөөцийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, танин мэдэхүйн хичээлийн 1-12 дугаар ангийн хичээлийн хөтөлбөр, гарын авлага, тус бүрд 39 төрлийн хичээлийн хэрэгсэл, 14 төрлийн ном, 55 төрлийн видео хичээлийг тус тус хүлээлгэн өгсөн. Ажлын гүйцэтгэл 100%.</p> <p>18. Орчны бүсийн ард иргэдийн амьжиргааг дэмжих ажлын хүрээнд /ҮАТ 2.18/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/113 дугаар тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/208 дугаар тушаалаар 311,932,826.00 төгрөгийн үнийн дүн бүхий ҮТА-№01-02/21, 21/228 дугаартай гэрээг “Дугант бар” ТББ-тэй 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсны дагуу гүйцэтгэгч байгууллага барилгын ажлын зургыг гаргаж, батлуулах шатандаа байна. 2022 оны 08 дугаар сарын 28-ны өдөр дуусах гэрээний дагуу тус ажлын гүйцэтгэлийг 2022 оны III улиралд багтаан хүлээн авахаар төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 30%.</p>
	<p>Зорилт 3 Үндэсний болон бүсийн түвшинд ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх</p>	<p>1. Биологийн олон янз байдлыг хамгаалах зөвлөл болон бусад сэдэвчилсэн ажлын хэсгийн хурлуудыг зохион байгуулах /ҮАТ 3.01/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/65 дугаартай тушаалаар БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулснаар төслийн хүрээнд хэрэгжиж буй зөвлөх үйлчилгээний ажлын явцын болон эцсийн тайланг хэлэлцүүлсэн. Үүнд: ТХГН-т халиун буга, янгир ямааны популяцийн нөөц тархалтын судалгаа хийх, /2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр/ Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийг бэхжүүлэх, БОЯБ-ын холбоос нутгийг тодорхойлох загвар төсөл хэрэгжүүлэх, Хангайн нурууны БЦГ-т ойн загвар төслийг хэрэгжүүлэх, бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх, ТХГН дахь хог хаягдлын менежментийг сайжруулах, ТХГН-ийн ойн тогтвортой менежментийн суурь судалгаа /2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр/, Хангайн нурууны БЦГ-т бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх /2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр/ зөвлөх үйлчилгээний нийт 7 ажлыг зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлж, шийдвэр гаргуулан, тайланг хүлээн авсан актуудыг албажуулсан. Ажлын гүйцэтгэл 100%.</p>

**Зорилт 3
Үндэсний болон
бүсийн түвшинд
ТХГН-ийн
сүлжээг
бэхжүүлэх
болон бүсийн
түвшинд Тусгай
хамгаалалттай
газар нутгийн
сүлжээг
бэхжүүлэх**

2. ТХГН-т биологийн олон янз байдлын судалгааг шалгуур үзүүлэлттэй уялдуулан нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэх, халиун бугын популяцид нөөц тархалтын судалгаа хийх /ҮАТ 3.02/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаартай тушаалаар 67,500,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-1/1021, 21/148 дугаартай гэрээг "ШУА-ийн биологийн хүрээлэн"-тэй 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байгуулж ажилласны дүнд судалгааны тайланг Биологийн олон янз байдлыг хамгаалах зөвлөлийн хурлаар 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцэж, тус ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. Ажлын гүйцэтгэл 100%.

Монгол орны халиун бугын тархац болон говийн Алтайн салбар ууланд бүртгэгдсэн халиун бугын байршлын мэдээнд үндэслэн амьдрах орчны тохиромжтой нутгуудыг загварчлан гаргаж, тэдгээрийн хоорондох боломжит холбоос нутгуудын зураглал, болон хамгийн бага саад бартааг туулж хүрэх холбоос коридоруудыг тооцон зураглал хийсэн. Уур амьсгалын хэтийн өөрчлөлтийн загварчлалаар халиун бугын тархах боломжит нутгийг тооцоолон үзэхэд 2040 он хүртэл хумигдан багасах, 2040-2060 онд тархац нутаг хойд зүгт бага зэрэг шилжих ба 2100 он гэхэд говийн бүсэд тархацгүй болох хандлагатай байгааг судлан тогтоосон.

3. ТХГН-т биологийн олон янз байдлын судалгааг шалгуур үзүүлэлттэй уялдуулан нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэх, янгирын популяцид нөөц тархалтын судалгаа хийх /ҮАТ 3.03/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг (KfW) банкны "Гэрээ шууд байгуулах" журмын дагуу зохион байгуулсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/105 дугаартай тушаалаар 69,500,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-1/1021, 21/147 дугаартай гэрээг "ШУА-ийн биологийн хүрээлэн"-тэй 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байгуулж ажилласны дүнд судалгааны тайланг Биологийн олон янз байдлыг хамгаалах зөвлөлийн хурлаар 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцэж, тус ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. Ажлын гүйцэтгэл 100%.

Энэхүү ажлын дүнд Тарвагатайн нурууны Алаг Ямаат орчим янгир ямааны тархах боломжит 799.5 км² нутгаас 217.51 км² нутагт 180 гаруй толгой янгирын сүрэг 0.83 бодгаль/км² нягтшилтайгаар тогтвортой тархан байршиж, тоо толгой өсөж байгаа ч үржлийн эрчим буурах хандлагатай байгааг судлан тогтоосон.

4. Ойн загвар төслийг шалгуур үзүүлэлттэй уялдуулан нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэх /ҮАТ 3.04/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/58 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/143 дугаартай тушаалаар 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдөр 63'400'000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-01/1821 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг "Шинжлэх ухааны академи, Газарзүй геоэкологийн хүрээлэн"-тэй байгуулсан. Гэрээний дагуу загвар төслийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хэлэлцэж, тус ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. Ажлын гүйцэтгэл 100%

Ойн тогтвортой менежментийг Хангайн нурууны БЦГ-т нэвтрүүлснээр ойн экосистем сэргэх, хамгаалалт, нөөц, зохистой ашиглалт сайжрах, ойн хомсдол, доройтол буурах, нутгийн иргэдийн амьжиргаа сайжирч, байгаль хамгаалалд оролцоо нэмэгдэх болно.

Зорилт 3
Үндэсний болон
бүсийн түвшинд
ТХГН-ийн
сүлжээг
бэхжүүлэх
болон бүсийн
түвшинд Тусгай
хамгаалалттай
газар нутгийн
сүлжээг
бэхжүүлэх

5. Бэлчээрийн менежментийн загвар төслийг шалгуур үзүүлэлттэй уялдуулан нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэх /ҮАТ 3.05/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/58 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/121 дугаартай тушаалаар 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр 68,100,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-1/1821 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг "Шинжлэх ухааны академи, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн"-тэй байгуулсан. Загвар төслийн эцсийн тайланг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан бөгөөд тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцэж, тус ажлыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар, үүрэг даалгаврын биелэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлэхээр шийдвэр гарсан. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 95%.

Бэлчээрийн тогтвортой менежментийг Хангайн нурууны БЦГ-т нэвтрүүлснээр бэлчээрийн даац, газрын доройтол буурах, хамгаалалт, нөөц, зохистой ашиглалт сайжрах, нутгийн иргэдийн амьжиргаа сайжирч, байгаль хамгаалалд оролцоо нэмэгдэх болно.

6. УТХГН-ийн хамгаалалттай холбоотой үйл ажиллагааг цахимжуулах, веб хөгжүүлэлт хийх, төрийн цахим үйлчилгээний E-Mongolia платформд холбох /ҮАТ 3.06/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/57 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/152 дугаартай тушаалаар 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдөр 45,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-1/2021, 21/192 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг "Софт мастер" ХХК-тай байгуулсан. Зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг тус яамны ТХБНУГ-аар 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хэлэлцэж, ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. Ажлын гүйцэтгэл 100%.

УТХГ ашиглах эрх авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газрын зураглалын бүртгэлийг солбицол өндөр, тусгалын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, бусад салбар хоорондын мэдээлэл солилцооны уялдааг хангахын тулд газрын кадастрын нэгдсэн систем "Ланд менежер" программ хангамжийн ашиглалтын төрөлд нэмэлт хөгжүүлэлт хийж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах эрхтэй холбоотой өргөдөл, хүсэлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн.

7. ТХГН-ийн ХЗ-дын зарим үйл ажиллагааг цахимжуулах /ҮАТ 3.07/:

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.

БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/198 дугаартай тушаалаар 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 34,900,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-1/2021, 21/216 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг "И-софт" ХХК-тай байгуулсан. Зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг тус яамны ТХБНУГ-аар ондоо багтаан хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Гэрээний хугацаа 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр, 2022 эхний сард багтан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу

<p>Зорилт 3 Үндэсний болон бүсийн түвшинд ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх болон бүсийн түвшинд Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх</p>	<p>50%.</p> <p>8. ТХГН-ийн үйл ажиллагаа зорилго, байгаль хамгаалагчдын талаар иргэд нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, зөв зохистой аялалд уриалах маркетингийн аяны контент бэлтгэх жишиг төсөл хэрэгжүүлэх /ҮАТ 3.08/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/199 дугаартай тушаалаар 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 34,500,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-1/1921, 21/218 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг “Рэтэ” ХХК-тай байгуулсан. Зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг тус яамны ТХБНУГ ондоо багтаан хэлэлцэж, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар шийдвэрээ ирүүлнэ. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 50%.</p> <p>9. Орон нутгийн ТХГ-н менежментийг бэхжүүлэх, БОЯБ холбоос нутгийн хамгааллыг хөгжүүлэх загвар төсөл 3.09/: БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/628 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Коконэт” ТББ-тай байгуулагдсан 234’711’250.00 төгрөгийн үнийн дүн бүхий ҮТ-06/2019 дугаартай гэрээний дагуу загвар төслийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хэлэлцэж, тус ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. Гэрээний дагуу нийлүүлэх бартаат замын 6 ш мотоцикл болон нисгэгчгүй нисэх 3 төхөөрөмж /дрон/-ыг 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Дорнод аймагт байрладаг “Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн. Үлдсэн тоног төхөөрөмж болох /майхан, дуран, байршил тогтоогч/ зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийн нийлүүлэлт /Ковид 19/ цар тахлын нөхцөл байдлын улмаас хил хаагдсантай холбогдуулан хойшилсон. Тоног төхөөрөмжийг нийлүүлснээр 2022 эхний улиралд багтан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг гаргахаар ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 90%.</p> <p>Түмэнхаан-Шалз ОНТХГ нь Онон Балжийн байгалийн цогцолборт газар, Тосон Хулстайн, Яхь нуурын болон Угтам уулын байгалийн нөөц газруудын хооронд биологийн олон янз байдлын шилжин нүүдэллэх, өсөн үржих таатай нөхцөлийг бүрдүүлсэн холбоос нутгийн загварыг бий болгосноор Кластерийн хэмжээнд хэрэгжих төслийн II шатанд загвар төслийн туршлага, сургамжийг ашиглан, байгалийн нөөц, биологийн төрөл зүйлийн хамгаалал, зохистой ашиглалтыг хөгжүүлсэн бүс нутаг болгох зорилготой.</p>
<p>Зорилт 4 Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа</p>	<p>1. Чадавхыг бэхжүүлэх сургалт, уулзалт /ҮАТ 4.01/: Тайлант хугацаанд Төсөл хэрэгжүүлэгч нэгж, Зөвлөх баг, БОАЖЯ болон бусад оролцогч талуудыг чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэхүү сургалт, уулзалт зөвлөгөөнийг цар тахлын үед мөрдөх журмыг баримтлан цахимаар зохион байгуулсан болно.</p> <ul style="list-style-type: none"> • KfW банкны худалдан авах ажиллагааны журам болон Шууд худалдан авалт /2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр/ • Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендер явуулах журам /2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр/ • Төслийн үнэлгээ, мониторингийн систем /2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр/ Ажлын гүйцэтгэл 100%.

